



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 4/58

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан нэг иргэнд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цпо ХХК-ийн "Стар" дэн буудлын 13/84 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 05 сарын 30
өдрийн 158 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.05.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ч.Дүүрэндэлгэр	Бэрс	Баянгол дүүрэг, 6-р хороо, Жамсранжавын гудамж 56

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 05 сарын 30
өдрийн 1/5 тоот тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.05.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Монгол Цэн Тай ХХК	Вен зоу	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжүгийн гудамж 19
2	Цэгц Шагай ХХК	Мираж	Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, 21-р хороолол, Үйлдвэрчний эвлэл 55

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2016 оны 05 сарын 30
өдрийн 157 тоот тушаалын гуравдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.05.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Цпо ХХК	Стар	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Их тойруугийн 36

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 20.21 оны 05 сарын 30
өдрийн 1/53 тоот тушаалын дөрөвдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.05.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Хонгор Экспедишн ХХК	Хонгор Гэст хаус	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Тавин мянгат 15-р байр 4,5,6 тоот

-ooOoo-